

Япон Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яам  
дараах ажлын байранд нэг /1/ хүнийг  
сонгон шалгаруулж авна

Тавигдах шаардлага

1. Ажлын ерөнхий агуулга  
Элчин сайдын өргөө, ЭСЯ-ны оффис болон орон сууцны ашиглалт, техник, засвар үйлчилгээ хариуцсан ажилтан.
2. Ажлын цаг
  - Даваа-Баасан /Нийтийн баярын өдөр, бусад амралтын өдрүүдэд амарна./
  - 09:00-17:45 /Үдийн амралт 1 цаг, 13:00-14:00 /
  - Амралтын өдрүүд, оройн цагаар ажиллах тохиолдол бий.
3. Цалин
  - Боловсрол, ажлын туршлага зэргийг харгалзан дотоод журмаар тогтоож, сар тутам олгоно.
  - Нийгмийн даатгал, цалингийн нэмэгдэл, урамшуулал цалин, цалинтай амралт, илүү цагийн хөлс олгогдоно.
4. Тавигдах шаардлага
  - Монгол Улсын иргэн
  - Техник технологийн холбогдох коллеж эсхүл дээд сургууль төгссөн, барилгын засвар үйлчилгээ, барилгын ажлын туршлагатай, барилга, цахилгаан, сантехник, мэдээллийн технологийн аль нэгээр мэргэшсэн (тус ЭСЯ-нд шууд ажиллах чадвар туршлага бүхий техник, засвар үйлчилгээний ажилтан) байх.
  - Өдөр тутмын ярианы япон эсвэл англи хэлний мэдлэгтэй бол давуу тал болно.
  - Бие, сэтгэцийн хувьд эрүүл
  - Япон, Монгол болон бусад улсад хэрэг зөрчилд холбогдож байгаагүй.
5. Сонгон шалгаруулалт
  - /1/ Бичиг баримтын бүрдүүлэлт
    - /а/ Анкет /монгол эсвэл япон хэлээр бэлдэх/ маягт харгалзахгүй бөгөөд гэрийн хаяг, овог нэр, нас хүйс, төрсөн он сар өдөр, боловсролын байдал, ажил эрхэлсэн байдал, гэр бүлийн байдал зэргийг тодорхой бичихийн хамт 4смх3см хэмжээтэй цээж зургийг хавсаргасан байна.
    - /б/ Иргэний үнэмлэхний хуулбар
    - /в/ Сүүлд төгссөн сургуулийн диплом, үнэмлэхний хуулбар
    - /г/ Бусад эзэмшсэн мэргэжлийн үнэмлэх, сертификатын хуулбар
  - /2/ Бичиг баримт ирүүлэх хугацаа  
9-р сарын 13-ний /баасан/ 17:00 цаг хүртэл ЭСЯ-ны төв хаалганы Харуулын хэсэгт (Санхүүгийн хэлтэст хаяглах) авчирч өгнө. /шуудангаар бичиг баримт хүлээн авахгүй./
6. Сонгон шалгаруулалтын хуваарь  
Ярилцагын шалгалт: тухайн үед товлоно (Бичиг баримтын шалгаруулалтын дараа).
  - Зөвхөн тэнцсэн хүмүүс рүү холбоо барьж, дараагийн шалгаруулалтын тухай дэлгэрэнгүй мэдэгдэнэ. Тэнцээгүй тохиолдолд мэдэгдэхгүй.
7. Ажилд орох хуваарь  
2024 оны 10-р сар.
8. Холбогдох утас  
Японы ЭСЯам, Санхүүгийн хэлтэс, утас: 320-777